

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу худалдан авах ажиллагаанд оролцож байгаа аж ахуй нэгжид хуулийн хугацаанд 2022 онд нийт 155 албан бичгийг хүргүүлэн ажилласан. Үүнээс гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл 31, шалгараагүй мэдэгдэл 124 тус тус хүргүүлсэн ажилласан байна.

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Тус дүүргийн Худалдан авах ажиллагааны албанаас зарласан Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын зөөлөн эдлэл нийлүүлэхээр ирүүлсэн танай тендерийг Үнэлгээний хорооноос Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 28 дугаар зүйлийн 28.7.3 дахь хэсэгт заасны дагуу “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендерээр шалгаруулан гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гарсан байна.

Иймд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасны дагуу энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш тендер хүчинтэй байх хугацаанд багтаж дүүргийн Засаг даргын Тамгын газартай гэрээ байгуулахыг мэдэгдье.

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Тус дүүргийн Худалдан авах ажиллагааны албаны Үнэлгээний хорооны 2022 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн хурлаар ЧДХААА-ДОНХС-А22/21 дугаар бүхий “Гудамж сайжруулах (13-р хороо)” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт ирүүлсэн танай тендерийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн (цаашид “хуулийн” гэх) 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийг үндэслэн хянан үзэхэд дараах шаардлагыг хангаагүй байна.

ТБОНӨХБАҮХАТ- хууль	Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл	Оролцогчийн ирүүлсэн мэдээлэл
Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дэх заалт	ТШЗ 37.1Төсөвт инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн 3,236.000 (гурван сая хоёр зуун гучин зургаан мянган) төгрөг тооцож ирүүлнэ.	Төсөвт инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн тооцож ирүүлээгүй байна.
Хуулийн 16 дүгээр зүйлийн 16.1.4 дэх заалт	Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл	Хөдөлмөр аюулгүй байдлын хувцасны мэдээлэл ирүүлээгүй байна.

Иймд танай ирүүлсэн тендерийг хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсгийг үндэслэн шаардлагад нийцээгүй гэж үзэж, тендерээс татгалзаж шийдвэрлэсэн болно.

Тус дүүргийн Худалдан авах ажиллагааны албаны Үнэлгээний хорооны 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн хурлаар ЧДХААА-ДОНХС-А22/15 дугаар бүхий "Гудамж сайжруулах /10-р хороо/" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт ирүүлсэн танай тендерийг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн (цаашид "хуулийн" гэх) 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийг үндэслэн хянан үзэхэд дараах шаардлагыг хангаагүй байна.

ТБОНӨХБАУХАТ-хууль	Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл	Оролцогчийн ирүүлсэн мэдээлэл
Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дэх заалт	<p>ТШЗ 15.6.5 Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт: "Шаардана"</p> <p>Одоо хийж байгаа болон хийхээр төлөвлөсөн ажлын тухай дэлгэрэнгүй мэдээлэл, тэдгээр гэрээний талаар лавлах мэдээлэл авч болох үйлчлүүлэгч, захиалагчийн хаягийг мөн МАЯГТ 7-ын дагуу ирүүлнэ.</p> <p>Одоо гүйцэтгэж байгаа ажилтай бол тайлбар ирүүлэх ба дуусаагүй ажлын гүйцэтгэл нь 70 хувиас багагүй байх ба инженер техникийн ажилтнууд нь давхцахгүй байгааг нотлох баримтыг ирүүлнэ. Инженер техникийн ажилтнууд нь давхацсан тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</p>	<p>Манайхаас зарласан Гудамж сайжруулах /12-р хороо/ гүйцэтгэгчээр шалгарсан.</p> <p>Гүйцэтгэж байгаа ажлын мэдээлэл ажлын явцын талаар ирүүлээгүй байна.</p>

Иймд танай ирүүлсэн тендерийг хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсгийг үндэслэн шаардлагад нийцээгүй гэж үзэж, тендерээс татгалзаж шийдвэрлэсэн болно.

Үнэлгээний хорооны гаргасан дээрх шийдвэрийг эс зөвшөөрвөл хуулийн 54.1, 55.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргаж болохыг үүгээр мэдэгдэж байна.